



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Дадлага, сургуулилалт зохион байгуулах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолууд, Шадар сайдын өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-ын дагуу газар хөдлөлтийн үед дуут дохиогоор ажиллах дадлага, сургуулилалтыг төвийн хэмжээнд зохион байгуулан, мэргэжил арга зүйгээр удирдан ажиллахыг Гамшгаас хамгаалах штабын дарга, Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/-т үүрэг болгосугай.

2. Дуут дохиогоор ажиллах дадлага, сургуулилалтыг зохион байгуулахдаа өдрийн цагаар ажиллаж байгаа бүх эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг бүрэн хамруулж, гамшгаас хамгаалах штабын мэргэжлийн ангиудыг бэлэн байдалд шилжүүлж, цаг үеийн мэдээ авч, эргэн мэдээлж үр дүнтэй ажиллахыг Гамшгаас хамгаалах штабын нийт бие бүрэлдэхүүн, клиникийн эрхлэгч, багийн ахлагч нарт үүрэг болгосугай.

3. Дадлага сургуулилалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зохион байгуулж, мэдээ тайланг Эрүүл мэнд, спортын яам, Онцгой байдлын ерөнхий газар, Баянзүрх дүүргийн онцгой байдлын хэлтэст тус тус хүргүүлэхийг Гамшгаас хамгаалах штабын дарга, Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/, Штабын нарийн бичгийн дарга, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн /С.Ариунболд/ нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

000200